

ХҮЧИРХИЙЛЭЛ БА ШАШИН

А. Жамбал – ШУА-ийн философи, социологи, эрхийн хүрээлэнгийн дэд захирал

Түлхүүр үг: терроризм, нүгэл буян, шашны дайн, шашны шүүх, эрхэт тэнгэр, хүнлэг ёс, нигүүлсэл, бурхны шашин, христын шашин, ислам, жихад.

Хүчирхийлэл ба шашин тус бүр өөрийн мөн чанар, зорилго, утга агуулга, арга хэрэгсэлтэй бие даасан үзэгдэлүүд юм. Хэдийгээр ийм боловч тэдгээр нь түүхэнд хоорондоо харилцан нөлөөлөлтэй байсан нь орчин үед ч түүхэн тодорхой байдлаар үргэлжлэн илэрсээр байна.

Бидний эл өгүүлэл хүчирхийлэл, шашин хоёрын харилцан нөлөөллийг авч үзэхэд зориулагдсан учраас эхлээд тэдгээр тус бүрийн мөн чанар, онцлогийн талаар өгүүлэх шаардлагатай болно.

I

Хүчирхийлэл нь хүний нийгмийн амьдралын аль ч хүрээ, ялангуяа улс төрийн амьдралын уг шинжээс урган гардаг, хүн, нийгэм, тэр дотор төртэй хамт үүсэн бий болсон нэн эртний түүхтэй үзэгдэл юм. Хүчирхийлэл хэмээх ойлголтоор илэрхийлэгдэж буй нийгмийн бодит үзэгдэл нь илрэх хэлбэр, хүрээ, хэрэглэгдэх арга зам, хэрэгсэл, субъект, шинж чанараараа олон талтай, өргөн агуулгатай. Хүчирхийллийг түүхэн тодорхой байдлаар, төр, нийгмийн анги бүлэг, гэр бүлийн хүрээн дэх хүчирхийлэл гэх мэтээр дотор нь ялгавартай хандаж ангилан авч үзэх явдал түүнийг судлаж танин мэдэх шинжлэх ухаанч шаардлага, арга зүйн чухал зарчим болно. Бид энд хүчирхийллийг нийгэм–улс төрийн үзэгдэл болох талаас нь, улс төрийн үүднээс үзвэл хүчирхийлэл бол нийгэм–улс төрийн янз бүрийн эрэмбэ шатны субъектууд, тухайлбал нийгмийн давхраа, бүлэг, хэсэг, институционал байгууллага, хувь хүмүүсийн хоорондын эрх ашиг, байр суурь, зорилго, үнэт зүйлс, үзэл санааны ялгаа, зөрчил, тэмцэлээс урган гарсан, сэргэлдэж буй талуудын нэг нь нөгөөдөө хүсэл зоригоо хүчирхийллийн арга хэрэгсэлээр тулгаж түүний эрх, эрх чөлөөнд халдаж, булааж буй үйлдэл гэж ойлгож болно.

Хүчирхийлэл хүн төрөлхтөний түүхэнд түүнийг сүүдэр мэт дагасаар иржээ. Үүнтэй холбогдуулж орчин үеийн соёлт, иргэншсэн хүн төрөлхтөн, улс гүрэн, тодорхой нийгэм, тэр дотор хүмүүсийн хоорондын харилцаа, гэр бүл, хувь хүний амьдрал үйл ажиллагаанд хүчирхийлэл багасаж буурсан уу, эсвэл өнгөрсөн зуунуудын түвшинд хэвээр байна уу, аль эсвэл бүр өсөж нэмэгдсэн үү гэсэн асуулт тавьж болно. Тэгвэл зарим нэг шалгуураар хандвал хүчирхийлэл өнөөгийн нийгэмд буурч хор хөнөөл, үр дагавар нь багассаар байгаа, өөр нэгэн шалгуураар бол өмнөх түүхэнд байсан шигээ хэвээр байна, зарим талаараа бүр өсөж, илрэх хэлбэр, төрөл зүйл нь олширч улам нарийн, хурц болж байна гэж хэлж болно.

Орчин үед хүн төрөлхтөний амьдралд хүчирхийлэл төдийлөн буурахгүй хэвээр байгаагийн үндэс шалтгаан юунд байна вэ? Нэлээд ерөнхий байдлаар хандаж үзвэл XX зууны эхнээс төгсгөлийн 90–ээд он

хүртэл хүн төрөлхтөн, дэлхийн улс орнууд капитализм, социализм гэсэн хоёр хэсэг, тэдгээрийн нөлөө, ноёрхлын хүрээнд хуваагдаж хоорондоо бодлогын чухал, гол хэрэгсэлийн нэг болж хэрэглэгдэх үндэс шалтгаан болж байлаа.

Гэтэл тэрхүү хуваагдалын нэг тал, хоёр системийн нэг нь болох социализм нурж унаснаар хүн төрөлхтөний амьдрал жам ёсны гольдролдоо орж нэг чигтэй, нэг төрөлтөй, амгалан тайван, сайн сайхан, шударга, ардчилсан шинжтэй болно гэсэн нь домог, хуурмаг явдал болох нь улам бүр тодорхой болж байна. Харин ч дэлхийн ганц их гүрэн бусдыг жанжлах, ноёрхох бодлого, үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн хэвээр, санасандаа хүрэх боломж нь нээгдсэн байдалтай болов. Хүчирхийлэл хүчирхийллийг бий болгодог нь ч хэвээр үргэлжилж байна. Эн зэрэгцэх өрсөлдөгчгүй ганц их гүрний жанжлах бодлогыг бусад улс орон өөр өөрийн бололцоо чадлаар сөрөн зогсож, эсэргүүцэн тэмцэж байгаа нь дэлхийн хэмжээний улс төрийн бодлогод хүчирхийлэл хэвээр хадгалагдах, шинэ хэлбэр, илэрэлтэй болоход хүргэж байна.

Өнөөгийн дэлхий ертөнц, хүн төрөлхтөн түүхийн шударга голдиролд бүрэн орж чадаагүй, өөрөөр хэлбэл жингийн цуваа жигдрээгүй байна. Өмнөх түүхийн олон зуун жилийн шударга бус, тэгш бус явдал, боолчлол, колончлол, хүчирхийллээс үлдсэн ачааны үлдэгдэл, түүний тусгал бүхий хир буртаг, бараан сүүдэр өнөөдөр ч бүрэн арилаагүй байна. Дэлхийн хэдэн арван үндэстэн, угсаатан өөрийн төр улсыг байгуулж чадаагүй, эрх ашиг нь зөрчигдсөн хэвээр байна. Тэгээд ч түүнийгээ сэргээн тогтоох, гүйцэлдүүлэх оролдлого, хөдөлгөөн тэмцэлдээ хүчирхийллийг гол хэрэгсэл болгож хэрэглэхийг зорьж байна.

Нийгмийн амьдралд хүчирхийлэл гарах үндэс шалтгаан, хүчин зүйлс ямагт түүхэн тодорхой байдаг. Тиймээс гарч буй хүчирхийллийг ямагт тодорхой байдлаар авч үзэж судлах шаардлагатай. Тэгж байж бодит үнэнд хүрнэ.

Өнөөдөр дэлхийн олон оронд нийгмийн амьдралын янз бүрийн хүрээ, түвшинд гарч буй асуудал, бэрхшээл, зөрчил хийгээд нийгмийн янз бүрийн давхраа, бүлгүүдийн ялгаатай, зөрчилтөй эрх ашгийг үндэсний төр засаг нь тэр бүр зүй зохистой, шударга илэрхийлэх, хамгаалах, зохицуулан шийдвэрлэх хүсэл зориг, чадвар дутаж байгаа нь нийгмийн амьдралд гарч буй хүчирхийллийн нийгэм-эдийн засаг, улс төрийн үндэс, шалтгаан болж байна. Өөрөөр хэлбэл нийгэмд гарч буй хүчирхийллийг субьектив байдлаар тайлбарлан ойлгох, тухайлбал хүчирхийлэл нь бусдыг ноёрхон дарангуйлах, хүчирхийлэх гаж буруу дур сонирхол, садист зан төрх, үзэл ухамсар бүхий согогтой этгээдийн дур зоргоос аяндаа урган гарч буй субьектив үзэгдэл мэтээр ойлговол эндүүрэл болно. Тэгэхдээ хүчирхийлэл гарахад нөлөөлж буй субьектив хүчин зүйл, заримдаа зохиомол чанартай хүчин зүйл ч байгааг хэлэх хэрэгтэй.

II

Шашин бол нийгэм-соёлын үзэгдэл бөгөөд ертөнцийг үзэх үзлийн хэв маяг, нийгмийн ухамсарын нэг хэлбэр, хүний тайтгарал, хүн чанарынх нь хүнийсэл гэх мэт олон талтай юм. Шашин өөрөө өөрийгөө тайлбарлан

ойлгодог, бас шашны философи түүнийг тайлбарладаг. Эдгээр тайлбар ёсоор бол орчлон ертөнц, түүний үй түмэн юмс үзэгдлийг эрхэт тэнгэр (god, бог) хэмээх ер бусын, туйлын хүч, ертөнцийн эзэн бүтээсэн бөгөөд удирдан чиглүүлж байдаг аж. Шашин бол хүн үүнд итгэж үнэмшсэн итгэл үнэмшил, мэдлэг, ухамсар хийгээд залбирал, мөргөл, зан байдлын нийлбэр юм.

Шинжлэх ухаан, тэр дотор шашин судлал шашныг дээрх тайлбараас өөр байдлаар тайлбарлан ойлгодог. Шинжлэх ухаан судалгаандаа бодит байдал хийгээд түүний тодорхой баримтыг иш үндэс болгодог. Шинжлэх ухааны хувьд ертөнцийн эзэн бүхий эрхэт тэнгэр үнэхээр оршдог, эсвэл эс оршдог нь туршлагаар барин тавин тогтоогдох, нотлогдох аргагүй зүйл юм. Тиймээс хүмүүнлэгийн ухааны нэг салбар болох шашин судлал эрхэт тэнгэрийг авч үзэж судалдаггүй, харин эрхэт тэнгэр бий гэж итгэн үнэмшээд, түүнийг шүтэж, түүнд залбиран мөргөж буй сүсэгтнүүдийн үзэл санаа, шашны ухамсар, зан байдал, зан үйл, түүнчлэн шашны байгууллага болох сүм хийд, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааг судалдаг. Шинжлэх ухаанд тулгуурласан шашин судлалын хувьд эдгээр бодит үзэгдэлүүд бол шашны амьдралын бодит баримт, судлагдахуун болдог.

Орчин үеийн шашин судлал, түүний янз бүрийн үзэл баримтлал, хандлагууд шашин хэмээх нэгдмэл, цогц үзэгдэлийг хэдийгээр өөр өөрийн ойлголт, парадигм, арга зүйгээр авч үзэж ойлгодог ч гэсэн тэдгээрийн дундаас нийтлэг ойлголт, ерөнхий үзэл санаа ямар нэг хэмжээгээр гарч байгаа юм. Түүнийг энд хураангуйлан гомьёолж илэрхийлбэл шашин бол ухаант хүн өөрийн зовлон, байгал, нийгмийн хүчний өмнө хүч бололцоо мөхөсдсөн сул дорой байдал, түүнчлэн эрүүл саруул, сайн сайхан аж төрж амьдрах хүсэл мөрөөдөл, тэмүүлэлээ санаагаараа бүтээсэн эрхэт тэнгэр хэмээх далдын хүчинд залбиран мөргөх, итгэж үнэмших хэлбэрээр сэтгэл санаандаа хуурамчаар нөхөж, гүйцэлдүүлж буй байдал юм. Шашин бол хүнд гаднаас тулган хүлээлгэсэн, эсвэл тэнгэрээс илгээгдэж буусан ер бусын зүйл биш, харин хүний өөрийнх нь уг чанар, байгал, нийгэмтэй харилцах харилцаа, юмс үзэгдлийг танин мэдэх, оюун санаа болон үйл ажиллагаагаараа эзэмших оролдлогын бэрхшээл, зөрчилөөс урган гарсан ухаант хүний өөрийнх нь бүтээл болно.

III

Хүчирхийлэл ба шашин нь мөн чанар, уг шинж, зорилгоороо хоорондоо эрс ялгаатай, тиймээс ч нийгмийн амьдралд тус бүрдээ өөр өөрийн байр суурь, оногдсон үүрэгтэй байдаг нь тэдгээрийн тулгуур чанар юм. Гэвч эл хоёр үзэгдэл хоорондоо ихээхэн ээдрээ зөрчил бүхий харилцан нөлөөлөлтэй болно. Энэ нь тэдгээрийн аль алиных нь субъект, тээгч нь хүн, хүмүүсийн бүлэг байдагтай нягт холбоотой.

Хүчирхийлэл ба шашны хоорондын холбоо, харилцан нөлөөлөл зөрчилтөй, олон талтай юм. Хүчирхийлэл нь хүний оршихуй, амьдрал, эрх, эрх чөлөө, хүмүүнлэг зорилго, хүсэл тэмүүлэлд эсрэг чиглэсэн нүгэл, тодруулж хэлбэл нийгэм-улс төрийн нүгэл (social and political vice, социально-политическое зло) байдаг. Тиймээс шашинд үзүүлэх хүчирхийллийн нөлөө, харилцаа нь сөрөг шинжтэй, хор хохиролтой үр дагавартай байдаг. Хүчирхийлэл шашныг өөртөө хэрэгсэл болгож ашиглахыг хичээдэг нь олонтоо тохилддог. Харин шашин өөрийнхөө

хүмүүнлэг, энэрэнгүй чанараараа хүчирхийллийг буруушааж эсэргүүцдэг нь давамгайлдаг. Гэвч шашин өөрийн зорилгодоо хүчирхийллийг хэрэгсэл болгож ашигладаг түүхэн баримтыг бас анхаарч авч үзэх хэрэгтэй. Хүчирхийлэл ба шашин хоёр нь нүгэл хийгээд буян, муу хийгээд сайн, хатуу хийгээд зөөлний хоёр туйл учираас тэдгээрийн хоорондын харилцаанд шашинд үзүүлэх хүчирхийллийн нөлөө нь бүхэлдээ сөрөг байдаг бол харин шашин нь өөрийн хүмүүнлэг, нийгүүлсэнгүй, амирлангуй чанараараа хүчирхийллийг хазаарлан барих, багасгах, намжаах, зөөлрүүлэх үүрэг нөлөөтэй байдаг.

IV

Одоо дэлхийн том шашнуудын ном судар, сургаал номлол хийгээд бодот түүхэнд хүчирхийллийн асуудал ямар байдлаар туссан, илэрч байсан талаар товч өгүүлье.

Хүчирхийллийн асуудал нэг талаас философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээ, нөгөөтэйгүүр шашны сургаал номлолд өөр өөр байдлаар тавигдаж тусгалаа олж байжээ. Философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхэнд хүчирхийллийн асуудал гол төлөв шууд утгаараа, тухайлбал хүчирхийллийг үндэслэн зөвтгөсөн, эсвэл буруушааж няцаасан байдлаар тодорхой тавигдаж иржээ. Гэтэл шашин хүчирхийллийг нүгэл хэмээн буруушааж ирсэн нь давамгайлдаг. Буддын ба христийн шашин хүчирхийллийн эсрэг хүчирхийллээр, шашны өөрийнх нь хэллэгээр нүглийн эсрэг нүглээр тэмцэж болохгүй гэж сургадаг. Тэгэхдээ дэлхийн том шашин тус бүр; хүчирхийллийн асуудал өөрийн ялгаа онцлогтойгоор тавигдаж иржээ.

Дэлхийн хамгийн эртний, ууган том шашин болох буддын шашин хүчирхийлэл, ер нүгэлийг туйлаас цээрлэн тэвчиж гаргахгүй байхыг тууштай номложээ. Тиймээс буддын шашин хүчирхийллийн үзэл санаанаас хамгийн ангид, нэн их хүмүүнлэг, нигүүлсэнгүй үзэл санаа бүхий шашин юм. Тэгэхдээ буддын шашинтай улс оронд түүнийг өөрийнх нь үйл хэргийн тусын тулд, түүнчлэн үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд туг, хэрэгсэл болгон ашиглаж байсан тохиолдол цөөнгүй бий билээ.

Дэлхийн монотеист, ганц бурхан шүтдэг том шашин болох иудайн ба христын шашин, тэдгээрийн ариун ном судар Библи, тухайлбал түүний Хуучин гэрээсийн хэсэгт дарлал, мөлжлөг, шударга бус явдлын эсрэг хүчлэн тэмцэх, өөрөөр хэлбэл нүгэлийн эсрэг нүгэлээр тэмцэх тухай үзэл санаа тодорхой хэмжээгээр туссан байдаг. Жишээлбэл Хуучин гэрээсийн "Египетээс гарсан нь" хэмээх хэсэгт: "Харийн хүнийг бүү буруутга, бүү дарла. Та нар аливаа бэлэвсэн эмэгтэй, эсвэл өнчин хүүхдийг бүү зовоо. Хэрэв та нар тэднийг зовоогоод, тэд над руу хашхирвал би тэдний уй гашууг сонсож, Миний уур хилэн дүрэлзэж, Би та нарыг илдээр ална. Та нарын эхнэрүүд бэлэвсэрч, та нарын хүүхдүүд өнчрөх болно" гэжээ (22:21-24). Энэ нь христын шашны номч гэгээнтнүүд, тухайлбал хутагт Афанасий (293-373), Амвросий (340-397), Августин (354-430), Аквины Фома (1225-1274) нар хүчирхийлэл, тухайлбал дайн, тэр дотор шударга ба шударга бус дайны асуудлыг авч үзэж шударга дайныг зөвтгөн үндэслэхэд багагүй нөлөөлжээ.

Христын шашны түүхэнд хүчирхийллийг хэрэгсэл болгон ашиглаж байсан баримт няцаагдашгүй билээ. Энд XI-XIII зуунд гарч байсан

-дарангуйлал, хэрцгий засгийн эсрэг тэмцэгч өөр ард олон хэрэв мусульманчуудад өөрсдөө хандаж тусламж хүсвэл тэдэнд бүх талаар, тэр дотор цэрэг зэвсгийн хүчээр ч туслах, тэдний талд байлдах хэрэгтэй;

-мусульманчууд өөрийгөө хамгаалж хориглосон шударга, ариун дайн хийх явцад дайны үйл ажиллагаа, үйлдлээс өөр хэрээс хэтэрсэн, зүй бус үйлдэл хийж болохгүй, тухайлбал хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшид, тахир дутуу хүмүүсийг доромжлох, албадаж хүчирхийлэх, амь насыг нь хороох, ашиг хонжоо хайж дээрэм тонуул хийх, дайны олзыг зүй бусаар хувьдаа завшихыг хатуу хориглоно;

-хэрэв мусульманчуудын хоёр бүлэг бие биетэйгээ дайтвал тэдгээрийг хооронд нь эвлэрүүлэх ёстой, хэрэв тэдний нэг тал нь нөгөөдөө шударга бусаар хандаж түрэмгийлэн дайтаж байгаа бол түүний эсрэг дайтаж шударга талд туслах хэрэгтэй;

-шашны ариун дайнд оролцогчид эрэлхэг, зоригтой, үнэнч шударга байх ёстой, хэрэв дайны талбарыг орхиж зугтвал хатуу шийтгэгдэнэ;

-өөрийн гэсэн зэр зэвсэг, эд хэрэгсэлгүй хүмүүс, шашны зүтгэлтэн, эрдэм номын хүмүүс, эцэг эх нь дайнд оролцохыг зөвшөөрөөгүй хүмүүс, бусдад өр зээлтэй бөгөөд зээлдүүлэгч нь дайнд оролцохыг зөвшөөрөөгүй хүмүүс шашны төлөө ариун дайнаас албан ёсоор чөлөөлөгдөнө. (Эдгээр заасан зүйлүүдийг Коран судрын дараах бүлэг зүйлээс үзнэ үү. Үүнд: 2:190-194, 216-217; 4:74-77; 8:39-40, 56-75; 9:1-8; 7:28, 16:92-95; 22:40-41; 60:7-9; 25:54; 49:9-11. (Энд эхний тоогоор Кораны бүлгийн дугаар, хоёр цэгийн дараахь тоогоор уг бүлгийн зүйл-аятын дугаарыг тэмдэглэсэн болно).

Ислам шашин сургахдаа дайн, чухамдаа түрэмгий, шударга бус, гэрээ хэлэлцээр, итгэл эвдсэн дайн, хүчирхийлэл, аллага бол мусульманчуудын зорилгодоо хүрэх арга хэрэгсэл огт биш гэдэг. Гэвч ислам шашин хамгаалах, хориглох дайныг бас огт үгүйсгэхгүй. Исламын энэ байр суурь, үзэл санааг Коран сударт "Дайн бол мусульманчууд та нарын хувьд хүсмээргүй жигшүүрт гэмт хэрэг мөн боловч бас зайлшгүйн эрхээр та нарт үүрэг болж оногдоно" гэж илэрхийлжээ [2:216].

V

Шашин ба хүчирхийллийн харилцан нөлөөллийн асуудлыг бүхэлд нь товч өгүүлбэл дэлхийн аль ч шашин хүчирхийллийг шууд үндэслэж зөвтгөдөггүй, харин зэмлэн буруушаадаг нь нийтлэг шинжтэй юм. Орчин үед дэлхийн аль ч тив, бүс нутаг, улс орнуудад шашинтай ямар нэг хэмжээгээр нэр холбогдсон хүчирхийлэл, террорист үйлдэл гарч байгааг тусгайлж, тодорхой авч үзвэл зохино. Энэ бол бие даасан том асуудал учираас бид энд дараах зүйлийг товч дурдахыг хүсэж байна.

Юуны өмнө орчин үеийн мэдээллийн хэрэгсэлүүдээр үзэл суртал, улс төрийн бодлогын зорилгоор аль нэг шашнаар овоглон тодотгож мэдээлдэг хүчирхийлэл, террорист үйлдэлийг үнэн хэрэгтээ шашны албан ёсны байгууллага болох сүм хийд, шашны тэргүүн, зүтгэлтэн, жинхэнэ хувраг хүмүүс шууд зохион байгуулж, удирдан хийлгэж байна уу, эсвэл шашны нэр хүнд, нөлөөг баг, халхавч болгож ашигласан улс төр, цэрэг, бизнес, гэмт хэргийн бүлэглэл бүхий этгээд үйлдэж байна уу гэдгийг ямагт ялган салгаж, тодорхой судлан шинжлэх хэрэгтэй юм. Аль нэг шашныг шүтэдэг сүсэгтэн этгээд ямар нэг учир шалтгаанаар хүчирхийлэл, террорист үйлдэл

үйлдснийг үндэс болгож тэрхүү үйлдлийг тухайн шашнаар овоглон тодотгох нь буруу бөгөөд тэр нь бодит үнэнд хүргэхгүй.

VI

Шашин бол хүнийг жинхэнэ хүн болгож хүмүүжүүлэх, сэтгэл, оюун санаа, үйл байдлыг нь хүнлэг энэрэнгүй болгож төлөвшүүлэхэд асар их ач тустай нийгмийн хүмүүжлийн том байгууллага (институт) мөн билээ. Тиймээс дэлхийн том шашнууд хүчирхийллийг буруушааж эсэргүүцдэг чухал үйл ажиллагаа, хүмүүжлийн үүрэг, ач холбогдол, тэр дотор хүнлэг ёсны тухай сургаалыг нь тусгайлан авч үзэж судлах, хүн ардад таниулж ухааруулах явдал өнөө үед чухал болж байна.

Дэлхийн том шашнуудын аль нь ч хүн хэмээх ээдрээ зөрчилтөй, буян нүгэл хослосон хэцүү бэрх амьтныг чухамдаа буяныг эрхэмлэсэн, хүнлэг чанартай жинхэнэ хүн болгохыг зорьж хичээсэн нийгмийн хүмүүжлийн анхны том хэлбэр, харьцангуйгаар системтэй боловсрогдсон, шашны ариун ном сударт томьёолон бичигдсэн ёс зүйн анхны номлол байжээ гэж үзэж болно. Дэлхийн том шашнууд бүгдээрээ нүгэл буян, үнэн худал, шударга ёс ба шударга бус явдал, хүнлэг ёс ба хүнлэг бус үйлдлийг хооронд нь нарийн зааглан ялгаж тодорхойлоод "хүн бүү ал" "бүү хулгайл", "худал бүү хэл", "бүү гүтгэ", "бүү завхайр", хүнлэг, энэрэнгүй, өглөгч, шударга, үнэнч, дэг журамтай бай гэх зэрэг императив (эрс) шаардлагуудыг ижил утга агуулгаар дэвшүүлэн тавьсан байна. Дэлхийн шашнуудын ёс зүйн номлолд хүнлэг ёс, тухайлбал энэрэл, нигүүлсэлийн үзэл санаа, хэм хэмжээ онцгой чухал болж тавигджээ.

Дэлхийн том шашнуудын баримталдаг хүнлэг ёсны зарчим, хэм хэмжээ, энэрэл, нигүүлслийн тухай сургаал нь нийт хүн төрөлөхтөний шинж чанартай, нийтлэг, түгээмэл агуулгатай байна. Тиймээс хүчирхийлэлтэй тэмцэх, түүнийг үл тэвчих үзэл, амьдралын байр суурийг төлөвшүүлэх талаархи олон талтай үйл ажиллагаа, тэр дотор сургалт боловсрол, гэгээрэл ба хүмүүнлэгийн бусад үйл хэрэг, ажил, арга хэмжээнд шашны хүмүүнлэг чанар, энэрэнгүй сургаал номлолыг аль болохуйц бүрэн ашиглах хэрэгтэй юм.

Манай оронд дэлхийн том шашнууд бүгдээрээ оршин үйлчилж, өөр өөрийн тодорхой орон зай, байр суурийг эзэлж байгаа бөгөөд тэдгээр нь өөрсдийнхөө сүм хийд, шашны сургууль, нийгэмлэг зэрэг байгууллага, номлодог сургаал, үзэл санаа, гэгээрүүлэх үйл ажиллагаагаараа дамжуулан хүн ардын сэтгэлийг засаж ариусгах, амарлингуй, төлөв түвшин, хүнлэг, энэрэнгүй болгох, хүчирхийллийн аливаа илэрэл, хэлбэрийг үл тэвчиж тэмцдэг болгох үйл хэрэгт ихээхэн үүрэг гүйцэтгэх хүч бололцоотой юм. Чухам үүнд нийгэм, хүний амьдралд шашин шүтлэг оршиж үйлчилэхийн жинхэнэ утга учир байгаа билээ.

Violence and religion

This titled article seems to be amaze for looking forward. But the violence and religion has related to those sides in the historical and contemporary generation that has influenced relatively.

An author has accorded to the general sample from greatest sush as Buddhist, Christianity and Muslim.

The violence has been using that religion to its own purposes, as well as, religious has been using that violence for own necessities in the history.

There are too many and great religious has been flourishing and developing in Mongolia also need for minimizing and releasing that violence from these religious humanities and merciful.

Ашигласан ном зохиол

1. Ариун Библи. Хуучин гэрээ Шинэ гэрээ. УБ., 2000
2. Бурхан багшийн сургаал. Токио, 1996
3. Гусейнов А.А., Апресян Р.Г. Этика. Учебник. М., 1998
4. Дмитриев А. В., Залысин И. Ю. Насилие (социо-политический анализ). М., 2000
5. Жамбал А. Ислам шашин. УБ., 2005
6. Коран. Перевод с арабского И.Ю. Крачковского. М., 1980
7. Основы религиоведения. Под ред. И.Н. Яблокова. 2-е изд. М., 1998
8. Политология. Энциклопедический словарь. М., 1993
9. Философский энциклопедический словарь. 2-е изд. М., 1989
10. Шашин судлал (Эхлэн суралцах бичиг). УБ., 2001